

Хороодын онцлох ажлыг батламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 02 дугаар тогтоол, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Хамтдаа хөгжье” хөтөлбөр батлах тухай 27 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус дүүргийн 1 дүгээр хороо нь “Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ажлын байрыг бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар ажилтай орлоготой болгох, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцө

лийг тэгш хүртээмжтэй хүргэх чиглэлээр хүүхэд залуучууд, ахмад, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог ханган олон талт ажлуудыг санаачлан зохион байгуулсан ажлууд, хороодын ажлын тайлан, Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын саналыг харгалзан хороодын 2018 оны онцлох ажлыг шалгаруулж хавсралтаар батламжилсугай.

2. Батламж гардуулах, алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хянан ажиллахыг Засаг даргын орлогч /Ж.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ